

ӨСВӨР ҮЕИЙНХНИЙГ АРХИДАЛТААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

*Н. Нямдорж
Доктор (Ph. D.)*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль*

nyamaa89@yahoo.com

Хураангуй: Өсвөр үеийнхний дунд согтууруулах ундааны талаарх мэдээлэл бага байдгаас архи уулаа ч архичин болох боломжгүй, бага градустай вино, пиво нь ямар ч хоргүй гэж ойлгон их хэмжээгээр ууж согтуурах үзэгдэл их байна. Архигүй баяр гэж байхаа больсон нь согтууруулах ундааг түгээмэл хэрэглэх шалтгаан болдог. Хэдий бага насандаа ууж эхэлнэ төдий чинээ илүү эрт архинд дасал болно. Нийгмээрээ архинд хавтгайран орсон нь олон сөрөг үр дагаварыг хойч ирээдүйд авчирч байгаа гэхэд хилсдэхгүй.

Өсвөр насны хүүхэд энэ насандаа аливаа юманд уруу татагдах сонирхол шохоорхол нь илүү байдагтай холбогдуулан янз бүрийн хорт зуршилын золиос болох нь ихэссэн. Монголын өсвөр үеийнхний 12-17 нас 70.6 хувь нь согтууруулах ундааг хэрэглэж үзсэн гэж ХЗДХЯ-наас Дэлхийн зөн, Архидалт Мансуурлын эсрэг ассоциацийн хийсэн судалгаагаар гарсан байдаг.¹

Өсвөр насныханы дундах архидалтын нөхцөл байдлыг судалж, архидалтыг бий болгогч шалтгаануудыг илрүүлэн, түүнийг бууруулахад чиглэсэн нийгмийн ажлын урьдчилан сэргийлэх үйлчилгээг санал болголоо.

Түлхүүр үгс: Өсвөр үе, архидалт, урьдчилан сэргийлэх нийгмийн ажлын үйлчилгээ

УДИРТГАЛ

Өсвөр насны хүүхэд энэ насандаа аливаа юманд уруу татагдах сонирхол шохоорхол нь илүү байдагтай холбогдуулан янз бүрийн хорт зуршилын золиос болох нь ихэссэн. Монголын өсвөр үеийнхний 12-17 нас 70.6 хувь нь согтууруулах ундааг хэрэглэж үзсэн гэж ХЗДХЯ-наас Дэлхийн зөн, Архидалт Мансуурлын эсрэг ассоциацийн хийсэн судалгаагаар гарсан байдаг. ² Судалгаанд

хамрагдсан 7000 гаруй хүүхдийн 45% нь архи, тамхи, мансууруулах бодисын сөрөг талыг огт мэдэхгүй байхад 7% нь л сайн мэднэ гэсэн бөгөөд үлдсэн 48% нь бага зэрэг мэддэг тухайгаа хэлсэн байна. Бидний ойр орчинд хаа сайгүй байх болсон энэ үзэгдэл нь ялангуяа гудамжны эсвэл эцэг эх гэр бүлийн хараа хяналт муу хүүхдүүдийн дунд илүү хурцаар явагдаж байгаа нь зайлшгүй судлах шаардлагатай байгааг харуулж байна.

¹ [https://www.chemn.moh.gov.mn/..](https://www.chemn.moh.gov.mn/)

² [https://www.chemn.moh.gov.mn/..](https://www.chemn.moh.gov.mn/)

“Архидан согтуурахтай тэмцэх” хуулиар 21 нас хүрээгүй хүнд архи худалдах, үйлчлэхийг хориглосон байдагч тэр бүр мөрдөхгүй байгаа нь нууц биш. Шөнийн цэнгээний газруудаар үйлчлүүлэгчдийн дийлэнх нь өсвөр үеийнхэн байдаг нь харамсалтай. Архины нэг гол аюул бол тархи мэдрэлийг хүчтэй цочроож хордуулдаг.

Нэг удаагийн согтолтоор 20 мянга гаруй мэдрэлийн эс үхдэг. Мэдрэлийн эс нэг үхвэл хэзээ ч нөхөн сэргэхгүй, улмаар уураг тархийг хордуулж, цаашлаад үхэлд ч хүргэх аюултай. Монголын ирээдүйг тодорхойлох шинэ үеийн хүүхэд залуучууд архи, мансууруулах бодисын талаар үнэн зөв мэдээлэл авч зохих хэмжээний мэдлэг эзэмшсэн байх ёстой.

Сэтгэл зүйн хувьд хүүхэд өөрийгөө “том хүн” боллоо хэмээн бодож “Насанд хүрсэн хүний” байр сууринаас аливаад хандахыг эрмэлзэнэ. Энэхүү мэдрэмжийн илрэл нь:

-Насанд хүрэгчдийн гадаад онцлог шинж, төрхийг дуурайх

-Нийгэмшихүйн хүрээнд дээрхи мэдрэмж нь насанд хүрэгч ба өсвөр насныхны хоорондын хамтын ажиллагааны явцад илрэх

-Оюун ухааны хүрээнд дээрхи мэдрэмж нь мэдлэг чадвараа нэмэгдүүлэх гэсэн хүсэл тэмүүлээр илэрч гарч байдаг.

Хүүхэд багш, аав ээж, гэр бүлийнхэнтэйгээ байхаас гадна хэний ч хараа хяналтгүй ганцаараа

байдаг цаг нь өдрийн 20 гаруй хувийг эзэлдэг аж. Тэр цагуудад гэмт хэрэгт холбогдох, хохирогч болдгийг цагдаагийнхан анхааруулсан. Архи дарс хэрэглэх үзэгдэл өсвөр үеийнхэн дунд түгээмэл байна. 2011 онд 175, 2012 онд 231, 2013 онд 264 хүүхэд эрүүлжүүлэгдсэн тоо энэ бүхнийг батална. Одоо харин эсрэгээрээ хэн ч, хаанаас ч аваад ууж болохоор элбэг, хямд байна, гэртээ харихдаа үнэртүүлэхгүй байх арга олчихно, ингэж бага багаар сонирхож, хэрэглэсээр сэтгэл санаа, бие махбодь нь дасч архины хамааралтай болох эхлэл тавигддаг. Тиймээс өсвөр насны хүүхдийн зан төлөвийг судалж, тулгамдаж буй асуудлыг нь шийдвэрлэх арга замыг тодорхойлох явдал чухал байна.

Судалгааны ажлын зорилго:

Өсвөр насныханы дундах архидалтын нөхцөл байдлыг судалж, архидалтыг бий болгогч шалтгаануудыг илрүүлэх, түүнийг бууруулахад чиглэсэн нийгмийн ажлын урьдчилан сэргийлэх үйлчилгээг санал болгох.

Судалгааны ажлын зорилтууд:

-Өсвөр насныханы дундах архидалтын нөхцөл, шалтгаануудыг судлах

-Өсвөр насныханд архины хор хөнөөл, сөрөг нөлөөллийн талаархи мэдлэг мэдээллийг дээшлүүлэх

-Сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээг судлах

Судалгааны ажлын судлах асуудлууд:

-Хүүхдүүдийн архины хор хөнөөлийн талаарх мэдлэгийн төвшин хангалтгүй дутмаг.

-Эцэг эхийн хараа хяналт, анхаарал халамж муугаас хүүхэд архи ууж байна.

-Найз нөхөд орчны нөлөөнд автаж байна.

-Өсвөр насныхан бие биеэ даган дуурайх, аливаа зүйлийг сонирхох, шохоорхох нь их байдаг. Үүнээсээ болж ямар нэг буруу, сөрөг зүйл хийх тохиолдол олон байна.

Судлагдсан байдал: Архины хэрэглээний талаар Монгол улсад бие даан хийгдсэн судалгаа цөөхөн байгаа ба архины хор уршгийг бууруулах, түүнээс үүдэлтэй сөрөг асуудлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох шаардлага өнөөгийн тулгамдсан асуудлуудын нэг болоод байна.

-Монгол өсвөр үеийнхний хэрэгцээг судалсан судалгааны тайлан 2000 он-1997 оны судалгааны үр дүнг дүгнэн авч үзсэн ба уг судалгаанд 2040 өсвөр насны хүүхдийн 16,4% тамхи татдаг бөгөөд тэдний 65,6% нь тамхинаас гармаар байна. Цаашдаа хамрагдсаны 2,2% мансууруулах бодис хэрэглэдэг буюу 10-16 насныхан голдуу бензин, гутлын тос, цавуу үнэрлэдэг гэсэн бол 17-20 насныхан 34% мансууруулах бодис хэрэглэж үзсэн байна.

-Сэтгэцийн эрүүл мэндийн мансууруулах бодисны талаарх

судалгаа. 2017 он – нийт эмчлүүлэгчдийн 81,2 % хараат хам шинжтэй нийт мансууруулах бодистой холбоотойгоор хэвтэн эмчлүүлэгчдийн мансууруулах бодис хэрэглэх шалтгаан дотор өөрөө сонирхож хэрэглэсэн 39,1% тайвшрах өвчин намдаах зорилгоор хэрэглэсэн 49,2% гэсэн шалтгаан дийлэнх хувийг эзлэж байна.

-ЦЕГ. 2015 оны мансууруулах бодисны хэрэглээний талаарх судалгаа -2015 онд 76 гэмт хэрэгт 169 хүн 2016 онд 109 гэмт хэрэгт 224 хүн 2017 онд 117 гэмт хэрэгт 282 хүн Эдгээр гэмт хэргийг нийтэд нь авч үзвэл 80-82% болох 19-35 насны залуус эзэлж байна. 2017 онд насанд хүрээгүй 203 хүүхэд хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн гэмт хэрэгт сэжигтэнээр татагдсан байна

-Нийслэлийн эрүүл мэндийн газар. Улаанбаатар хот. 2015 он-архи, тамхины хэрэглээ өсвөр үеийнхний дунд хийсэн судалгаанаас авч үзвэл нийт судалгаанд хамрагдагсдын:44.6% нь архи, 40.3% нь тамхи, 2.9% нь бензин, цавуу, 1.8% нь каннабис, 0.9% нь экстази хэрэглэж үзсэн гэж хариулсан байна.

-www.1212.mn Үндэсний статистикийн хорооны 2017 оны судалгаа – Монгол Улсын хувьд хүн амын 5 хүн тутмын 1 нь 15-24 насныхан байна. Тэдгээрийн 59,8% нь хотод 21% хотод амьдарч байна . 2017 онд нийт ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүний тоо насны

бүлгээр авч үзвэл 282 хүүхэд шүүхээс ял авсны 75% нь 16-17 насны хүүхэд 25% 14-15 насны хүүхэд эзэлж байна.

ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН НИЙГЭМ СЭТГЭЛ ЗҮЙН ОНЦЛОГ

НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, ДЭМБ-ын тодорхойлолтоор өсвөр нас гэдэг нь хүүхэд ахуй нас ба орь залуу насны хооронд орших үе шат бөгөөд 10-19 насныхан юм. Тэд бол бидний ирээдүйн үнэт баялаг билээ. Азийн Бүсийн орнуудад эрүүл мэндийн байдал, хөгжилд ихээхэн ололт амжилт гарч байгаа хэдий ч өсвөр үеийнхний эрэлт хэрэгцээг хангасан, үйл ажиллагааг дэмжсэн идэвх санаачилга шаардагдсаар байна. /ДЭМБ-ын НДББ-ийн захирал Шигору Оми/ хэлсэн байдаг.

Өсвөр нас гэдэг бол тэр чигээрээ харилцаа байдаг... Үүнийг эцэг эхчүүд насанд хүрэгчид тэр бүр ойлгохгүй “жаахан хүүхэд юу ч мэдэхгүй” гэсэн хандлага байсаар байна. Өсвөр насныхны хүүхдэрхэг төрх байдлын цаана байгаа “Том хүн” болох, насанд хүрэх чиг тэмүүлэлд гарч байгаа өөрчлөлтийг нь багш, эцэг эхчүүд олж хараагүй захирч тушаан буруу харьцсанаас болж зөрчил үл ойлголцлын зөрчил үүсэж байдаг. Сэтгэл зүйн өөрчлөлтийн илрэх зан үйл нь

уриалан дуудах, азаа турших, архи тамхи мансууруулах бодис хэрэглэх, бэлгийн харьцаанд орох, нийгмийн үйл ажиллагаанд оролцох,³ өөрийн эрхээ хамгаалах, өөрийн болон бусдын өмнөөс үүрэг хариуцлага хүлээх, зохион байгуулалттай элдэв зүйлд уруу татагдах зэргээр илэрч байдаг.

Хүүхдийн зан төлөвт олон төрлийн шалтгаанаас болж өөрчлөлт ордог. Үүнд:

-Биологийн сөрөг хүчин зүйлс /Тархины үйл ажиллагааны дутмагшил. Үр хөврөл ургийн хөгжлийн явцад болон төрөх үед мөн нялх насанд хүүхдийн тархинд гэмтэл, халдвар, хордлого нөлөөлөхөд хүүхдийн тархи үйл ажиллагааны дутмагшилтай болно. Сэтгэл мэдрэлийн өвчин, epilepsi, тархины усжилт, Дауны хам шинжийн үед, шизофрени өвчний далд үед, мэдрэлийн ядаргааны үед.

-Нийгэм сэтгэл зүйн сөрөг хүчин зүйлс /Эцэг эхийн уруу нөлөө, буруу хүмүүжил, муу зуршилд автамтгай хүүхэд, хараа хяналтгүй өсөж хүмүүжиж буй хүүхэд, хүүхдийг “гэрийн бурхан болгон шүтэх” хүмүүжил, шоовдорлох хүмүүжил, хатуу гарын хүмүүжил, асрамж халамж дутсан хүмүүжил, салсан гэр бүл, хуурамч эв түнжинтэй гэр бүл гэх мэт.

Өсвөр насны хүүхдийн архидалтанд нөлөөлж буй хүчин

³ Сэтгэл зүйн зөвөлгөө /Гэр бүл, хүүхдэд чигэлсэн арга зүйн асуудлууд/

зүйлсийг онолоор тайлбарлан авч үзвэл:

Нийгмээс суралцахуй онол:
 А-идэвхжүүлэгч үйл явдал, В-хүмүүсийн идэвхжүүлэгч үйл явдлын тухай бодол, итгэл үнэмшил, С-хүмүүсийн бодол санаа, итгэл үнэмшилийн үр дагаварыг илтгэнэ. Хүмүүс бусдын хийж буй үйлдлийг харж даган дуурайх замаар шинэ зан үйлийг сурах бөгөөд хэрэв зан үйлийг дэмжсэн орчин бүрдвэл (жишээ нь хийсэн үйдлийн үр дүн эерэг бол), тэр зан үйл дахин давтагдана гэж үздэг. Хэрэв сөрөг үр дагаваргүйгээр хүссэн үр дүндээ хүрвэл тэр үйлдлийг дахин хийх магадлал ихтэй гэж үздэг. Энэ бүгдээс хүмүүм муу зүйлийг орчноосоо сурдагтай адил хүмүүст эерэг шинэ зан үйлийг системтэй сургаж бэхжүүлэх дасал хийлгэснээр тэд шинэ зан үйлд сурах болно. Энэхүү онолын хүрээнд дүгнэн авч үзвэл тухайн өсвөр насны хүүхэд нь хорт зуршилд автах урьтал шалтгаан нь нийгмээс тухайн хүүхэд архи хэрэглэж үзэх дур сонирхол үүсэх зэрэг нь нийгмийн нөлөөлөл хамт олон, найз нөхөд , эцэг эх, хамаатан саданы сөрөг нөлөөлөөс шалтгаалж уг төрлийн хорт зуршилд автах суурь нөхцөл болж байна. Түүнчлэн нийгмийн нөлөөл буюу олон нийтийн орчинд нөлөөлж урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж нийгмийн олонхийн архины хор хөнөөлийг урьдчилан таниулсанаар өсвөр насны

хүүхдүүдийн хор зуршилд автах суурь шалгааныг бууруулж болно

Нийгмээс суралцахуйн онолын ABC (А-урьдал нөхцөл , В-зан үйл , С-үр дагавар) юуны өмнө өөрчлөхийг зорьж буй зан үйл, асуудлыг нөхцөл байдлын үнэлгээний үеп тодорхойлж тэр өөрчлөхөөр сонгосон зан үйлийг “зорилтот зан үйл ” гэж нэрлэдэг. Харин нөгөө хоёрын бүрэлдэхүүн хэсгийн нэг нь тэрхүү асуудалтай, өөрчлөхийг хүсэж буй зан үйлийн өмнө илрэх зан үйл буюу үйл явдал. Үүнийг урьдал нөхцөл – зан үйл гэж нэрлэдэг. Харин тэр асуудалтай зан үйлийн дараа илрэх зан үйлийг үр дагавар гэж нэрлэсэн. Сүүлийн хоёр бүрэлдэхүүн хэсэг бол өөрчлөх гэж буй зан үйлийг хянах тогтоох хүчин зүйл болдог.

	Урьдал нөхцөл /А/	Зан үйл /В/	Үр дагавар /С/
	Өсвөр насны С нь тамхи татах хорт зуршилтай болсоныг эцэг эх нь уурлаж бие махбодын хүчирхийлэл үйлдсэнд	Хүү С нь өөрийн хорт зуршилаас татгалзалгүй нууцаар хэрэглэх болсон	С нь өөрийн хор зуршилаас татгалзахаас зайлсхийж нууцаар олон давтамжтай хэрэглэх болсон
Зайн үйл өөрчлөх гэрээ	Эцэг эх нь хүү С гээ хор зуршил хэрэглэх зуршилтай болсоныг эцэг эх нь мэдээд түүний энэ зуршилаас гаргах урьдчилан сэргийлэх сургалт мэдээлэлд хамруулах хүсэлт тавьсан	Хүү нь хор зан үйлийн хор хөнөөлийн талаарх мэдлэг урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэлтэй болсон	С нь өөрийн зан үйлийг өөрчилж тамхи татах хорт зуршилаасаа гарч чадсан

Эрүүл мэндийн үнэмшлийн загвар /Health Belief Model/

Эрүүл мэндийн итгэл үнэмшлийн загвар (ЭМИҮЗ) нийгмийн эрүүл мэндийн салбарт

хамгийн түгээмэл хэрэглэдэг онол юм. Годфрей Хохбаум болон АНУ-ын нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажилладаг сэтгэл зүйчид анх 1950-иад оны эхээр үндэслэн сүрьеэгээс урьдчилан сэргийлэх үйлдэлд өвчтөнүүдийн хандах хандлагыг судлах зорилгоор ашиглаж байжээ. ЭМИҮЗ нь хүний үйлдлийг түүний бодол санаа, сэтгэл хөдлөл нь удирддаг гэсэн зарчим дээр тулгуурладаг. Хувь хүний зан үйлд нөлөөлдөг хэд хэдэн дотоод хүчин зүйлийг тодорхойлсон байдаг.Үүнд:

-Тухайн өвчөнд өртөх шууд эрсдэл өөрт бий эсэх талаар ойлголт (өртөмхий байдлын талаарх ойлголт)

-Тухайн асуудалд , өвчлөлийн ноцтой байдлын талаарх ойлголт , итгэл үнэмшил(ноцтой байдлын талаарх ойлголт)

-Эрсдэлийг буруулахын тулд хийж буй үйлдлийн үр дүн (ашиг тусын талаарх ойлголт)

-Тухайн үйлдлийг хийхэд шаардагдах үнэ цэнэ , уг үйлдлийг хийснээс гаргах үр дагавар (саад бэрхшээлийн талаарх ойлголт) харьцуулсан ойлголт⁴

№	Ухагдахуун	Практик хэрэглээ
1	Ноцтой байдлын талаарх ойлголт	Хорт зуршилын байнгын хэрэглээ нь хүний биед сөрөг нөлөө хэрхэн нөлөө үзүүлэх талаарх мэдээлэл суртчилгаа
2	Өртөмхий байдлын	Тухайн хорт зуршилд хүн бүр өртөж болох улмаар даамжирсаар донтолтонд хүргэж болох талаарх мэдлэг ойлголт

⁴ С. Алтанцэцэг. Өсвөр насны хүүхдүүдийг мансууруулах бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх нь

	талаарх ойлголт	
3	Ашиг тус, үнэ цэнийн талаарх ойлголт	Аливаа нэгэн хорт зуршилгүй байх нь тухайн хүний эрүүл амьдрах суурь үндсийн нэг бөгөөд аливаа хор зуршил нь эдийн засаг , гэр бүлийн харилцаа , нийгэмд эзлэх байр суурийг алдагдуулах үндэс болдог талаарх ойлголт мэдээлэл
4	Үйлдлийг хийх сэдэл	Хор зуршилд өртсөн хүмүүсийн бодит амьдралын талаарх кейс, бодит нөхцөл байдлыг харуулсан мэдлэг ойлголт
5	Өөртөө итгэх итгэл	Аливаа хорт зуршилд өртсөний дараа тухайн хорт зуршилаас гарах оролдлого хийснээс татгалзах нь илүү хялбар гэсэн мэдээлэл ойлголт хүргэх.

ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДҮҮДИЙН ДУНДАХ АРХИНЫ ТАЛААРХИ СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС


Судалгаанд Улаанбаатар хотын зургаан дүүргийн ЕБ-ын сургуулийн ахлах ангийн 120 хүүхэд хамрагдсан болно. Үүнд: БГДүүргийн 77-р ахлах сургууль, БЗДүүргийн 79-р сургууль, ХУДүүргийн 41-р сургууль, Чингэлтэй дүүргийн 17-р сургууль, СХДүүргийн 82-р сургууль СБДүүргийн 6-р сургууль тус тус хамрагдсан.

1 зураг. Судалгаанд хамрагдсан сурагчдын нас




Нийт судалгаанд хамрагдсан 120-н ахлах ангийн сурагчдын 19% нь 14-15 нас, 43% нь 16 нас, 38% нь 17-19 н настай сурагчид судалгаанд хамрагдсан.

2 зураг. Судалгаанд оролцсон хүүхдүүдийн хүйс



Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 54% нь эрэгтэй 46% нь эмэгтэй байна. Үүгээрээ өсвөр насны хүүхдүүдийн архины зан төлвийг эрэгтэй эмэгтэйгээр нь харьцуулж үзлээ.

3 зураг. Судалгаанд оролцсон гэр бүлийн байдал




Нийт сурагчдын 65 нь аав ээжтэйгээ амьдардаг, 31 нь аав ээжийн аль нэгэнтэй нь амьдардаг, 21 нь хагас өнчин, 3 нь бүтэн өнчин гэж хариулжээ.

Судалгаанд 6-н дүүргийн 6-н сургуулийн 120-н хүүхэд хамрагдсаны Гэр хороололд амьдардаг -62 хороолол дунд амьдардаг сурагчид -58 хамруулсан

нь хотын төв, зах 2-н хоорондын харилцааг харах зорилготой.

4 зураг. Судалгаанд оролцсон хүүхдүүдийн архины талаарх мэдээллийн эх сурвалж



Архины талаар мэдээлэл хаанаас авдаг вэ? Гэсэн асуултанд найз нөхөд, ангийхнаасаа-23, гэр бүлээсээ-25 ТВ, сонин сэтгүүл, интернэт ертөнцөөс -72 буюу хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа нь өсвөр насны хүүхдүүд ТВ, сонин сэтгүүл, интернэт ертөнцөөс бүхийл мэдээллийг авч байдаг нь харагдаж байна. Тийм учраас ТВ, сонин сэтгүүл, интернэт ертөнцөд архины хэрэглээ, хор уршигын талаар хангалттай мэдээлэл оруулах шаардлагатай.

5 зураг. Сурагчдын архины талаарх мэдлэгийн түвшин



Та архины хор хөнөөлийн талаар хэр их мэддэг вэ? Асуултанд бага зэрэг мэддэг -60% сайн мэднэ-40% огт мэдэхгүй гэсэн хариултыг нэгч сурагч сонгоогүй байна. Үүнээс үзэхэд өсвөр насны хүүхдүүдийн дийлэнх хувь нь архины хор хөнөөлийн талаар бага

мэдээлэлтэй байдаг нь харагдаж байна.

Гэр бүлийн гишүүдийн хэн нэгэн архины төрлийн зүйл хэрэглээний тухай асуултанд огт хэрэглэдэггүй-14%, хааяа хэрэглэдэг-18%, байнга хэрэглэдэг-68%тай гарч байгаа нь өсвөр насны хүүхдүүд гэр бүлээсээ үлгэр жишээ авдаг даган дуурайх хандлага өндөр байдаг нь ажиглагдаж байна.


6 зураг. Өсвөр насны хүүхдийн архины хэрэглээний тандалт



Судалгаанд оролцогчдын 67% нь архины төрлийн зүйл хэрэглэж үзсэн гэсэн үзүүлэлт нь өсвөр насны хүүхдүүдийн архины хэрэглээ өндөр байгааг харуулж байна. Харин хэрэглэж үзээгүй нь 23% байна.


Үүнээс үзэхэд өсвөр насныхан буюу ахлах ангийн сурагчдад сургуулийн нийгмийн ажилтны оролцоо, мэдээ мэдээлэл, санал зөвлөмж, сургалт семнар нэн чухал байгааг илтгэж байна.

7 зураг. Архины хэрэглээг насны байдлаар нь:



Судалгаанд оролцогчид хэдэн насандаа анх архины төрлийн зүйл хэрэглэж үзсэн бэ? гэсэн асуултанд 16-18-н насандаа хэрэглэж үзсэн нь 32%, 14-16 насандаа гэж хариулсан 36%, 14-оос доош насандаа гэж хариулсан нь 19% байна. Үүнээс үзэхэд архийг хэрэглэж байгаа нас жил ирэх тусам залуужсаар байна үүнд нийгмийн ажилтны оролцоо үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай:

8 зураг. Архины хэрэглээ



Та хэдэн удаа архины төрлийн зүйл ууж үзсэн бэ? Нийт сурагчдын 16% нь 10-с дээш удаа, 29% нь 5-н удаа, 42% нь 1 удаа, 13% нь хариулаагүй байна.

Судалгаанд оролцогчид архины төрлийн зүйл хэтрүүлэн хэрэглэж үзсэн үү гэсэн асуултанд хариулаагүй 16%, үзсэн 46%, үзээгүй 38% гэж хариулсан нь өсвөр насныхны дунд архины хэрэглээ өндөр байгааг харуулж байна.

11 зураг. Архины төрлийн зүйл хэрэглэхэд нөөлөөлсөн хүчин зүйл



Судалгаанд оролцогчид Анх архины төрөлийн зүйл хэрэглэхэд чинь нөөлөөлсөн хүчин зүйл юу вэ

? нэсэн асуултанд хариулаагүй 16%, найз нөхөд анги хамт олон 50%, гэр бүлийн орчин 11%, реклам зар суртчилгаа интегнэтийн орчин 23% гэж хариулсан байна.

Нийт судалгаанд оролцогч хүүхдүүдийн 18% нь найз нөхөд, ангийхан дунд архины төрлийн зүйл хэрэглэдэг хүүхэд олон байдаг, 73% нь зарим нь хэрэглэдэг, 9% нь огт байдаггүй гэж хариулсан байна.

Сурагчдын 40% нь архийг сонирхоод хэрэглэсэн гэсэн бол 36% нь найз нөхдийн шахалтаар, 11% нь гэр бүлийн асуудлаас гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд өсвөр насны хүүхдүүдийн хүүхэд насанд бий болсон ухамсарлагдаагүй шохоорхол хэрэгцээнээсээ болоод хэрэглэдэг болох нь харагдаж байна.

Ахлах ангийн сурагчдын архины хэрэглээний давтамжийг судлан үзэхэд 67% нь сардаа нэг удаа ямар нэг хэмжээгээр хэрэглэдэг гэж хариулсан нь анхаарал татсан асуудал бөгөөд сургуулийн нийгмийн ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч нар анхаарч ажиллах шаардлага байгааг харуулж байна.

ӨСВӨР НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ НИЙГМИЙН АЖЛЫН АРГА ЗҮЙ

Монгол улсад сургуулийн нийгмийн ажил үүсч хөгжөөд нилээдгүй жилийг ардаа үдсэн

боловч нийгмийн ажилтнуудын явуулж буй үйл ажиллагаа үйлчилгээ сурагч өсвөр насныханд тэр бүр хүрч чадахгүй байгаа нь дээрх судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Сургуулийн нийгмийн ажилтны хувьд хүүхдийн эрхийг дэмжсэнээр хүүхдүүдтэй хамтран тэднийг хүчирхийлэл дарамт, үл хайхрах байдал, ялгаварлал, мөлжлөгт орхоос нь урьдчилан сэргийлэх эрх ашиг нь зөрчигдсөн үедээ тусламж авах чадвартай болгоход нь нөлөөлдөг. Үүнээс дүгнээд үзвэл нийгмийн ажилтан өсвөр насныханд архины хэрэглээ, түүний хор хөнөөлийн талаар зөвөлгөө өгөх арга зүйн талаар мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах шаардлагатай. Ерөнхий боловсролын сургуулиудын Эрүүл мэндийн хичээлийн программд архины талаар мэдээлэл байдагч сурагчид төдийлөн хангалттай мэдээлэл авдаггүй нь харагдаж байна.

Сургуулийн нийгмийн ажилтны мэргэжлийн чиг үүрэг

Сурагчид тэдны гэр бүлийн гишүүдийн нийгмийн болон сэтгэлзүйн үйл ажилгааг сайжруулах, гэр бүлийн амжиргаа болон хүүхдийн сурлагийн амжилт, үзүүлэлтийг дээшлүүлэх зорилгоор нийгмийн үйлчилгээ, туслалцаа үзүүлэх ажил хийнэ.⁵

⁵ А. Батхишиг. Хүүхдийн хөгжлийн хэрэгцээ ба нийгмийн ажил

Нийгмийн ажлын үйлчилгээ

Нийгмийн болон хүмүүсийн сайн сайхны төлөө нөөц боломжыг нь илрүүлэх, хөгжүүлэх урьдчилан сэргийлэх, сэргээн засах, хамгаалах зорилгоор үзүүлж буй мэргэжлийн үйл ажиллагааны цогц юм.

Нийгмийн ажилтны ажлын байрны үндсэн зорилго нь:

-Хувь хүнд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх

-Хамт олон бүлэг болон гэр бүлд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх

Нийгмийн ажлын анхдагч урьдчилан сэргийлэлт

Анхдагч урьдчилан сэргийлэлтийн өнөөгийн байдал:

СЭМҮТ-өөс 2017 онд ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн суралцагчдыг хамруулсан судалгаа хийсэн байна. Судалгаанд хамрагдсан хүүхдийн 45 хувь нь архи, тамхи, мансууруулах бодисын сөрөг талыг огт мэдэхгүй байхад 7 хувь нь л сайн мэднэ гэсэн бөгөөд үлдсэн 48 хувь нь бага зэрэг мэддэг тухайгаа хэлсэн байна.⁶

	1997 он	2003 он	2017 он
Архины хор хөнөөлийн талаар:	Хор хөнөөлийн талаар:	Хор хөнөөлийн талаар:	Хор хөнөөлийн талаар:
хөнөөл, хэрэглээн ий талаар олон нийтийн мэдлэгийн түвшин	-19,3% сайн, -49,4 % дунд, -12,2 % хангалтгүй, -19,1% огт мэдэхгүй	-30 % сайн -38 % дунд -11,1 % хангалтгүй -20,9 % огт мэдэхгүй	-7 % сайн мэднэ -48% бага зэрэг мэддэг -45 % огт мэдэхгүй

Урьдчилан сэргийлэх ажлын агуулга мөн чанар:

Урьдчилан сэргийлэх ажлын арга нь үйлчлүүлэгчдэд өөрт нь байгаа стресс үүсгэгч эх үүсвэр, сурвалжийг үндсээр нь устгах төдийгүй үйлчлүүлэгчийн өмнө тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай туршлагыг эзэмших нийгмийн нөхцөлийг бий болгоход чиглэдэг. Урьдчилан сэргийлэх арга нь үйлчлүүлэгчдэд тавьсан зорилгодоо хүрэх, эрүүл мэндээ хамгаалахад нь туслах шинэ дадал, хэвшилд сургах явдлыг өөртөө агуулдаг. Урьдчилан сэргийлэх нь хараахан үүсэж амжаагүй байгаа асуудлыг шийдэхэд анхаардаг. Урьдчилан сэргийлэх нь асуудлыг үүсэхээс өмнө таслан зогсоох болон үйлчлүүлэгч тавьсан зорилгодоо хүрэх зохистой арга зам хувилбарыг олоход тусалдаг.

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төрөл:

-*Анхдагч урьдчилан сэргийлэлт.* Хүүхдийн бүх талын хөгжил буюу бие сэтгэц , нийгмийн эрүүл мэндийг бататгах сайжруулахад чиглэсэн нийгмийн ажлын цогц үйл ажиллагаа юм. Энэ нь бүх нийтэд чиглэсэн байдаг ба сөрөг, эрсдэлтэй зан үйлээс сэргийлэхэд ихээхэн үр ашигтай.

-*Хоёрдогч урьдчилан сэргийлэлт.* Өндөр эрсдэлтэй зан байдлыг сөрөг үр дагавар болон өвчлөл үүсэхээс урьдчилан сэргийлж

⁶ Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар

байгаа нийгэм, боловсрол , эрүүл мэнд, сэтгэл зүйн арга хэмжээнүүдийн нийлбэр юм. Энэхүү арга хэмжээг өндөр эрсдэлтэй зан үйл бүхий үйлчлүүлэгчдэд зориулан хэрэгжүүлдэг.

-*Гуравдагч урьдчилан сэргийлэлт*: Архины хэрэглээтэй холбоотой сөрөг үр дагавар, өвчлөлийг таслан зогсооход чиглэдэг.

Олон нийтэд түшиглэсэн урьдчилан сэргийлэх аргуудыг дараах байдлаар хийж болно. Үүнд :

- ✓ Эдийн засгийн арга нь байр, орон сууц, орчны нөхцөл байдлыг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглүүлэх
- ✓ Нийгэм-соёлын арга хэмжээ нь хүүхдийн биеийн болоод оюун санааны хөгжил, амралт, чөлөөт цагийн зохион байгуулалт, хүн амын соёлын хэрэгцээг хангахад чиглэх
- ✓ Нийгмийн зохион байгуулалт-хууль эрх зүйн арга хэмжээ нь байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хүүхэд залуучуудын харилцаа, сахилга батад хяналт тавих албадыг байгуулах, үйл ажиллагааг нь тогтмолжуулах
- ✓ Сэтгэл зүйн арга нь сэтгэл зүйн боловсрол олгох, таагүй байдлаас гаргахад нь туслалцаа үзүүлэх, асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах мэдээлэл өгөх
- ✓ Сурган хүмүүжүүлэх арга нь хүн амын янз бүрийн бүлгүүдэд

амьдрах ухаан, хөдөлмөрлөх, хууль эрх зүй, ёс суртахууны хүмүүжил олгох, нийгмийн идэвх, оролцоог хөгжүүлэх

ДҮГНЭЛТ

Манай улсад сүүлийн жилүүдэд өсвөр үе, залуучуудын дунд дэлгэрэх хандлагатай байгаа архины хэрэглээний өнөөгийн байдлыг судалж үзэх, үнэлгээ дүгнэлт хийн, нөхцөл байдлыг тодорхойлох, улмаар үйл ажиллагааны цаашдын чиг хандлагыг боловсронгуй болгох, хор хөнөөлөөс сэргийлэх ажлыг эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Өсвөр насны хүүхэд нь алдаж эндэх зүйл их байдаг. Хөгжлөө дагаад хүмүүсийн хэрэгцээ, сонирхол өсөн нэмэгдэж, өөрчлөгдөж байгаа ч сүүлийн үед ялангуяа өсвөр үе, залуучуудын архины хэрэглээний түвшин харьцангуй өндөр байгааг судалгааны дүнгүүд харуулж байна. Судалгаанд оролцогчдын 60% нь архины талаарх ойлголт сайн бөгөөд 68% нь архины талаарх мэдлэг мэдээллийг сонин сэтгүүл, ТВ, интернэт ертөнцөөс, 17% нь гэр бүлээсээ, 15% нь найз нөхдөөсөө олж авдаг байна. Тиймээс ТВ, интернэт орчинд архины хор хөнөөлийн талаархи ухуулга сурталчилгаа тогтмол явуулах шаардлагатай. Архины хэрэглээг насны байдлаар нь авч үзэхэд 16-18 насандаа хэрэглэж үзсэн нь 36%, 14-16 насандаа гэж хариулсан нь 47%, 14 насандаа

17% хариулсан нь өсвөр насныхны дунд архины хэрэглээ өндөр байгааг харуулж байна. Үүнд ялангуяа сургуулийн нийгмийн ажилтны оролцоо, үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай байна гэж дүгнэлээ. Өсвөр насны хүүхдүүдийн хүүхэд насанд бий болсон ухамсарлагдаагүй шохоорхол хэрэгцээнээсээ болоод архиыг хэрэглэдэг болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Судалгааны асуудлын хүрээнд өсвөр насныхан бие биеэ даган дуурайх, аливаа зүйлийг сонирхох, шохоорхох нь их байдаг. Үүнээсээ болж ямар нэг буруу зүйл хийх тохиолдол олон байдаг гэсэн таамаглал батлагдаж байна.

Санал зөвлөмж :

- Сургуулийн нийгмийн ажилтан хүүхдийн хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлэх агуулга бүхий илэрцийг таслан зогсоох түгээхгүй байх
- Хүүхдийн санаа бодлыг сонсох, шийдвэр гаргах үйл ажилгаанд идэвхитэй оролцуулах, тэдний санаа бодолд тулгуурласан үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжоор хангах
- Хүүхэдтэй харилцахдаа чөлөөтэй, илэн далангүй байх, шаардлагатай мэдээлэл өгөх, дэмжлэг туслалцаа үзүүлэх
- Өсвөр насны хүүхдийн шийдвэр гаргах үйл явцад найз нөхөд нь гол үүрэг гүйцэтгэдэг учраас эцэг эх, багш сурган

хүмүүжүүлэгчид хоорондоо уялдаа холбоотой ажиллах

- Хүүхэдтэйгээ байнга ярилцах, тэдний юу хийж, юу бодож, юу мэдэрч байгааг асууж байх
- Хүүхдийнхээ хаана хэнтэй цагийг өнгөрүүлж байгааг анхаарч байх
- Аливаа зүйлд хандаж байгаа хандлага, ойр дотныхонтойгоо харилцах харилцаанд өөрчлөлт гарч байгаа эсэхийг ажиглаж байх
- Хүүхдийнхээ ололт амжилт бүрт сайшаан магтаж, урамшуулж, түүний давуу талыг мэдрүүлэх, өөртөө итгэх итгэлийг дээшлүүлэх, үүрэг хариуцлагаа ухамсарлан ойгоход нь туслах
- Эцэг эхчүүд хүүхдэдээ тавих анхаарал халамжаа сайжруулах
- Хүүхдийг гэртээ байх тав тух орчин бүрдүүлэх
- Дугуйлан, секцэнд нь явуулж завгүй байлгах
- Хүүхдээ урамшуулж магтаж байх
- Хүүхэдтэйгээ илэн далангүй ярилцах

НОМ ЗҮЙ

1. Донтох эмгэг судлал. Л.Эрдэнэбаяр. УБ хот. 2014 он
2. Хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргууд. УБ хот.2017 он
3. Бие хүний сэтгэл зүй, сэтгэц заслын өрнөдийн онол, гол төлөөлөгчид УБ хот. 2003он
4. Хүүхэд хамгааллын үндэс. С.Энхтуяа. Улаанбаатар хот. 2009 он
5. Хүүхдийн хөгжлийн хэрэгцээ ба нийгмийн ажил. А.Батхишиг 2002 он

6. Зан үйлийн төлөвшил ба оролцоо НҮБ хүүхдийн сан 2008 он

7. Нийгмийн ажилтнуудын практик туршлага Каритас чех ТББ 2010 он

8. Сэтгэл зүйн зөвөлгөөний үндэс Н.Ариунтуяа, Х.Гэрэлсүрэн 2015 он

9. Хүүхдээ хайрлах харилцах нь О.Мягмар 2001 он